




“АВАРГА ТОСОН РАШААН СУВИЛАЛ” ХХК

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



2026 он

БАТЛАВ:
БОУАӨЯ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

ХЭНТИЙН АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“АВАРГА ТОСОН РАШААН СУВИЛАЛ”
(ТӨСЛИЙН БАЙРШИЛ, НЭР)

2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2644495/

Хянасан:

Хэнтий Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

“Аварга тосон рашаан сувилал ” ХХК

Захирал Т.ТУУЛ / _____ /

“Аварга тосон рашаан сувилал ” ХХК

Мэргэжилтэн Э.УРАНЧИМЭГ / _____ /

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА

1. БҮЛЭГ 1 . ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.	Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	2
1.2.	Төслийн хүчин чадал	4
1.3.	Дэд бүтэц	5
1.3.1.	Цахилгаан хангамж.....	5
1.3.2.	Дулаан хангамж	5
1.3.3.	Зам харилцаа.....	5
1.3.4.	Усан хангамж	5
1.3.5.	Хог хаягдал	5

2. БҮЛЭГ 2 . ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3. БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1.	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ.....	10
3.2.	Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө	12
3.3.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
3.4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	14
3.5.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	15
3.6.	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	
3.7.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл**

Төслийн нэр:	Рашаан сувиллын цогцолбор
Төсөл хэрэгжүүлэгч:	“Аварга тосон рашаан сувилал” ХХК
Тусгай зөвшөөрөл:	Эрүүл мэндийн яамны 2013.01.10-ны ЭХ-03/23/3122 дугаар улсын хэмжээнд Сувиллын тусламж үйлчилгээ үзүүлэх гэрчилгээг авсан. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:
Төсөл хэрэгжүүлэгчийн регистрийн дугаар:	Регистрийн дугаар: 2644495 Харилцах утас: 7746-2222, 88881009, 80862262
Газар эзэмших эрхийн гэрчилгээ	Дугаар: 000007108 Олгосон он сар өдөр: Сумын Засаг даргын 2019.07.31-ны А/88 тоот шийдвэрээр 13 жилийн хугацаатай олгосон.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Хэнтий аймаг, Дэлгэрхаан сум, 3-р баг
Төслийн байршил:	Хэнтий аймаг, Дэлгэрхаан сум, 3-р баг, Аварга тосон нэртэй газарт үйл ажиллагаа явуулдаг.
Цахилгаан хангамж:	Багануур цахилгаан түгээх сүлжээ ТӨХК холбогдсон.
Усан хангамж:	Унд, ахуйн хэрэглээний усыг өөрийн гүний худгаас хангадаг.
Хүний нөөцийн төлөвлөлт:	Улирлын чанартай сувиллын үйл ажиллагаа явуулж жил бүр 7 алба бүхий 80-100 хүнийг ажлын байраар ханган ажилладаг.
Хүчин яадал:	Хоногт 300-350 хүн хүлээн авах бүрэн хүчин чадалтай байна.

“Аварга тосон рашаан сувилал” нь Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын 3-р багийн нутагт өөрийн эзэмшлийн 9.832 га талбайд далайн түвшинөөс дээш 1240-1260 метрийн өндөрт, Улаанбаатар хотоос 270 километр зайтай оршдог.

“Аварга тосон рашаан сувилал” нь Монгол орны томоохон рашаан сувиллын нэг бөгөөд хүмүүсийн амьдрал, эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах зориулалттай эрүүл мэндийн байгууллага юм.

Аураг рашаан: Аураг рашаан нь нүүрс хүчлийн хий CO_2 -р баялаг 88 метрийн гүнээс ундрал гардаг хүйтэн рашаан ус юм. Рашааны найрлагад орсон нүүрс хүчлийн хий, эрдэсжилтээс гадна түүний найрлаганд фтор, 2 валенттай төмөр, магни, титан, бари, зэс, лити, цайр оролцсон байдаг. Нүүрс хүчлийн хийт рашаан нь биеийн ерөнхий тамир тэнхээг сэргээх үйлчилгээтэй бөгөөд бие мах бодийн эд эсийн хүчил төрөгчийн хангамж ба оюуны ажиллах чадварыг сайжруулдаг. Аурагын рашаан нь ходоод гэдэсний архаг үрэвсэл, элэг, цөс, нойр булчирхай, сахарын диабет, эрдсийн солилцооны алдагдал зэрэг дотор эрхтний өвчинд хэрэглэхээс гадна ходоодны хүчил ихсэх, багасах мөн амны хөндий, буйлны үрэвсэл, хамар хоолойн харшлын гаралтай өвчин, шүдний өвчний үед зайлж хэрэглэнэ. Мөн толгойн өвчин, тархины даралт, уналтад шавшин хэрэглэдэг. Ялангуяа сахарын диабет өвчинд онцгой сайн үйлчилгээ үзүүлдэг.


Тосон шавар: Аварга тосонгийн анагаах шавар нь байгалд ховор тохиолдох өндөр эрдэсжилттэй, наалдамхай чанартай 3 төрлийн улаан шар, саарал, хар өнгөтэй нарийн ширхэгтэй тослог, лаг шавраас бүрдэнэ. Шаврын бүтцийн ширхэг хичнээн нарийн бөгөөд тослог, наалдамхай шинж чанартай байх тусам анагаах чанар нь сайн байдаг. Аварга тосонгийн эмчилгээний шавар нь дулааны физик чанар биологийн идэвхит бодисыг агуулсан органик эрдэсийн бүрэлдэхүүн, төмөр, зэс, кабалетын ислүүд, амин хүчлүүд, нүүрс ус төрөгч, хүхэрт ус төрөгч, азот, радон болон даавар, антибиотек, витамин төст нэгдлүүдийнхээ ачаар эмчилгээний өндөр ач холбогдолтой шаварт тооцогддог. Эмчилгээний шавар нь нянгийн эсрэг үйлчилгээтэй байдаг. Хүний биед шавар эмчилгээний үзүүлэх нөлөөнд дулааны үйлчилгээ голлох үүрэгтэй байдаг. Дулааны нөлөөгөөр шавар тавьсан биеийн хэсэгт судас тэлж, цусны эргэлт сайжирч, биеийн температур нэмэгдэж бодисын солилцоо сайжирдаг байна. Рашаан ус, шавар эмчилгээний эхний үед булчингийн агшилт суларч тамир доройтож байгаа мэт боловч курс эмчилгээний төгсгөлд цусны судлуудын тонус нэмэгдэж ургал мэдрэлийн цочрол багасч, булчингийн агшилт хүчтэй болон биеийн ерөнхий байдал сайжирдаг. Шавар эмчилгээ нь биеийн эсэргүүцлийг нэмэгдүүлж цусан дахь залгих болон хамгаалах эсийн чадварыг нэмэгдүүлдэг байна.

Тосон нуур: Нуурын эргийн элс нь нуурын доор байх эмчилгээний шаврын үргэлжлэл болох ба Аварга тосонгийн анагаах шавраас дутахгүй өндөр эрдэсжилттэй, олон төрлийн микро элемент агуулсан том ширхэгтэй элсээр бүтнэ. Нуурын эргийн элс нь рашаан нуурын хаялгаар байнга эрдэсжиж байдаг. Аваргын бүлэг рашааны эмчилгээний нэг хэсэг нь нуурын эргийн эрдэсжсэн элс, нарны эгц тусгал бүхий нуур орчмын эмчилгээний био уур амьсгал,

хужиран зам зэрэг нь анагаах ухааны олон төрлийн хүчин зүйлийг нэг дор цолцлоосон эмчилгээний ач холбогдол өндөртэй чухал хэсэг юм. Рашаан нуур нь олон мянган жилийн настай бөгөөд өндөр эрдэсжилттэй, найрлагандаа олон төрлийн органик бодис агуулсан, шавар, элсэн дээр газрын гүний усны ундаргаар тогтсон байгалийн рашаан юм. Тосон нуурын рашаан ус нь карбонат-гидрокарбонат, хлорт натри төрлийн өндөр эрдэсжилттэй жинхэнэ давст нуур юм. Рашаан нууранд орсноор хүний биеийн эрүүл мэндийг дэмжиж дархлааг сайжруулах үйлчилгээг үзүүлдэг байна. Нуурын усны долгионд хүний биед сайн макро болон микро элементүүд байдаг ба ялангуяа гормоны болон бодисын солилцоог сайжруулагч олон тооны биогений өдөөгч, дотоод шүүрлийн булчирхайн ажиллагааг идэвхжүүлэгч бодисууд байдаг ба тэдгээр нь нүдэнд харагдахгүй талст хэлбэрийн нимгэн давхаргаар арьсыг бүрхэж биед шингэн хүний бие организмыг дэмждэг байна.



Зураг 1. Төслийн ерөнхий тойм зураг



Зураг 2. Төслийн байршлын зураг

1.2. Төслийн хүчин чадал

Аварга тосон рашаан сувилал нь нэг ээлжиндээ 300-350 хүн хүлээн авах хүчин чадалтай. Зуны саруудад ажиллахдаа 2500-3000 гаруй хүн 200 ороор үйлчилдэг. Үүнээс жилд дунджаар нийт хүчин чадлынхаа 60-70%-ийг ашигладаг.

Сувилал нь үйлчилгээний эмнэлгийн тусламж үйлчилгээний байрнууд, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар, агуулах байр, гүний худаг, угаалгын байр, манаачийн байр, сувилуулагчдын аураг зочид буудал, рашаан буудал, тосон нуур цогцолбор, дүнзэн байр, сувилуулагчийн гэр хотхон, энгийн буудал, ажилчдын байр, кофе шоп гэсэн барилга

байгууламжтай.

Аварга тосон рашаан сувилал нь Улаанбаатар хотын захиалгын төв болон Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд байрлах сувилал дээр 7 алба нэгж бүхий 80-100 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн баг хамт олон ажилладаг.

1.3. Дэд бүтэц

1.3.1. Цахилгаан хангамж

Сувилал нь зуны 3 сар тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэ хугацаанд амралтын байр, хоолны газрын тоног төхөөрөмж, гадна талбайн гэрэлтүүлэг, ахуйн хэрэгцээний цахилгаан эх үүсвэрүүдийг Багануур дүүргээс өндөр хүчдэлээр дамжуулан хангах гэрээг байгуулан ажилладаг байна. Цахилгаан эрчим хүчнийхээ төлбөрийг хоорондын гэрээний дагуу төлбөрийг барагдуулдаг.

1.3.2. Дулаан хангамж

Төсөл нь дулааны 3 сарын хугацаанд үйл ажиллагааг явуулдаг бөгөөд шаардлагатай тохиолдолд цахилгаан халаагуураар шийдвэрлэдэг.

1.3.3. Зам харилцаа

Аварга тосон рашаан сувилал нь Улаанбаатар хотоос 270 километр зайтай засмал замаар явж очно.

1.3.4. Усан хангамж

Өөрийн эзэмшлийн талбайд гаргасан 1 худгаас амрагч, ажилчдын унд ахуйн хэрэглээний усыг татан ашигладаг.

Тус ус ашиглалтанд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас 2023 оны 01 дугаар сарын 2-ны өдрийн 01 дугаар ус ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна гэсэн дүгнэлтийн авсан.

1.3.5. Хог хаягдал

Шингэн хог хаягдал

Бохир усыг одоогоор бага оврын цэвэрлэх байгууламжаар дамжуулан MNS 4943:2015 стандартанд нийцүүлэн хөрсөнд шингээдэг байна.

Хатуу хог хаягдал

Сувилал бүрэн хүчин чадлаараа (300 хүн/өдөр) ажиллагсад 100 хүн ажиллана гэж тооцвол хоногт $400 \times 0.3 = 120$ кг, сард 3600 кг хатуу хог хаягдал гарахаар байна. Үйл ажиллагаа явуулах дулааны 3 сард 10.8 тн хатуу хог хаягдал гарахаар байна. Жилд дунджаар 7,5 тн гардаг

бөгөөд Дэлгэрхаан сумын аварга тохижилт үйлчилгээний газартай хог хаягдал ачин зайлуулах гэрээ байгуулан ажиллаж байна.

Аюултай хог хаягдал

Сувилал нь рашаан, шавар, нуурыг түшиглэн байгалийн эмчилгээг уламжлалт анагаах ухаантай хослуулан сувиллын үйл ажиллагааг эрхэлдэг байна. Гэвч тодорхой хэмжээний эм эмнэлгийн зориулалттай хэрэгслийн хаягдал гарах ба үүнийгээ Дэлгэрхаан сумын нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан зориулалтын цэгт битүүмжлэн хадгалан нийлүүлдэг.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хэнтий аймгийн нутгийн хойд хэсэг ойт хээр, уул нурууд нь ерөнхийдөө д.т.д. дунджаар 2100-2600 м орчим өндөрт өргөгджээ. Онон Балжийн голоос урагш хээрийн бүс залгана. Эндхийн уул нурууд нь намссаар ухаа гүвээ цав толгодод аажмаар шилжинэ. Уулсын өндөр нь д.т.д дунджаар 1300- 1500 м ерөнхийдөө нэгэн жигд өндөртэй. гал

Дэлгэрхаан сум нь Монгол орны физик газар зүйн мужлалын хувьд Хангай Хэнтийн уулархаг их муж Хэнтийн мужийн Хэнтийн захын уулсын тойрог, Монголын дорнод талын их муж Халхын дундад ухаа гүвээт талын тойргийн заагт оршино. Дэлгэрхаан сум нь уур амьсгалын хувьд эрс тэс уур амьсгалтай хуурайдуу сэрүүн зунтай бүсэд нөхцөлд оршино. Хамгийн хүйтэн үе нь 1-р сар бөгөөд дундаж температур нь өвөлдөө -15-аас -40 хэм хүртэл хүйтэрдэг бол хамгийн халуун өдөр нь 7 сард ба зуны дундаж температур +15-аас +37 хэм хүрдэг байна.

Голдуу хаврын улиралд салхины хүч 12м/сек-ээс 14м/сек хүрч зарим үед 16- 18м/сек хүрч салхилдаг. Өвлдөө дунджаар 5-аас 10 см зузаан усан бүрхүүл тогтдог. Жилийн анхны бороо 4 сарын эхээр анхны цас 9-р сарын дундуур ордог.н ус

Дэлгэрхаан сумын нутгийн баруун болон өмнөд хилийн дагууд Хэрлэн гол урсах бөгөөд нутгийн баруун өмнөд хэсгээр аажим тохойрон зүүн тийш гольдрол нь эргэдэг. Үүнийг Хэрлэнгийн Их тохой гэж нэрлэдэг. Сумын төвийн дэргэдээс эх авсан Аваргын гол урагш урссаар Хэрлэн голын солгой талаас цутгадаг нэгдүгээр эрэмбийн жижиг гол юм.

Сувилал нь Тосон нуурийн эргээс 150 метрийн зайд усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсээс 12 метрийн зайд энгийн хамгаалалтын бүсэд байрлана. Бүрд нуурийн эргээс 300 метрийн зайд, онцгой хамгаалалтын бүсээс 170 метр, энгийн хамгаалалтын бүсээс 80 метрийн зайд байрлаж байна.

Гадаргын хэв шинжийн хувьд тал хээрийн хэв шинж давамгайлсан том жижиг олон

нууртай, мөн голын эх болох газар тул нуга, намагтай газар байна. Үүнээс шалтгаалан нам дор газраа нугын болон аллювийн хөрс тархсан байгаа бол талархаг газраар хар хүрэн хөрс зонхилон тархсан байна.. Газрын гадаргын өндөршил нь далайн түвшнээс дээш 1240-1260 метр орчимд хэлбэлзэнэ.

Сувиллын талбай нь талархаг хэв шинжтэй, нуурын хөндийн дэнжийн систем илэрнэ. Нийт талбай 10 га бөгөөд нуурын хөндий, голын эхээр нугын, аллювийн, талархаг газраар хар хүрэн хөрсний хэв шинж зонхилон тархсан байна.

Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэрт дахь ургамлын төрөл зүйл нь уулын ойт хээрийн бүслүүрийн ургамлын ангилалд хамаарах ба энд ботууль, тужууны өвс, дааган сүүл зэрэг үетэн, заримдаг өвс бүхий уулын хээрийн ургамал болон таг, тагийн доод хэсгийн өндөр уулын ургамлаас гадна хээрийн ургамлууд холилдон ургадаг байна. Сувиллын эзэмшлийн нийт талбайн 30-50%-д ургамлан нөмрөгтэй байгаа нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд цаашид Газрын тухай хуулийн дагуу нийт талбайг бүрэн хэмжээгээр олон наст өвслөг ургамлан бүрхэвчтэй, үүний арваас дээш хувьд бут, модлог ургамал ургуулах шаардлагатай болсон байна.

Төслийн талбайн орчим зэрлэг амьтан, шувууд, хоёр нутагтан зэрэг амьтад тархан нутаглах бөгөөд 40 гаруй зүйлийн хөхтөн тэмдэглэгдсэнээс ердийн буюу хэвийн үзэгддэг 26, ховордуу 6, маш ховор буюу хааяа үзэгддэг 8 зүйл тархжээ. Үүний зонхилох хувийг мэрэгч, махчин амьтан эзэлдэг бөгөөд үлдсэн хэсгийг салаа туурайтан, туулай хэлбэртэн эзэлдэг. Нийт нутгаар болон ус намгархаг газруудаар суурин болон нүүдлийн амьдралтай цэн тогоруу, ангир, хун, тоодог, өвөөлж, хөх цэгций, элээ, хэрээ, шар шувуу, ууль, тоншуу, бргамал, амьтан юм.

№	Нөлөөлөлд өртөгч хүчин зүйлүүд	Тээврийн хэрсэгсэл		Барилгын ажил		Хатуу хог хаягдал		Шингэн хаягдал		Аюултай хаягдал		Дүн	
1.	Хүн амын эрүүл мэнд	1	0	0	0	1	0	0	0	5	0	6	0
2.	Агаар	1	4	2	5	2	2	2	1	2	3	9	15
3.	Хөрс	2	2	10	10	4	5	4	2	10	7	30	26
4.	Гүний ус	2	1	0	2	2	2	2	3	5	7	11	15
5.	Гадаргын ус	5	2	0	1	2	4	4	4	5	4	16	15
6.	Ургамал	5	5	10	10	4	5	4	2	10	7	33	29
7.	Амьтан	2	2	4	2	2	1	2	1	5	3	15	9
Дүн		27	16	26	30	17	19	14	13	42	31	100%	

Хүснэгт 1. Нөлөөллөх чанарын үнэлэлт

Үнэлгээний хүснэгтийн босоо багануудын нийлбэр дүнгээс үзвэл төслийн үйл ажиллагаа нь байгаль орчинд тогтвортой байдлыг алдагдуулахаар хэмжээний сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй нь харагдаж байна. Хэвтээ багануудын нийлбэр дүнгээс үзвэл хөрс, агаар, ургамал, усан орчин, амьтан зэрэг байгаль орчны бүрдэл хэсэг тус бүрт тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.




График 1. Нөлөөлөгч, өртөгч хүчин зүйлс

“Аварга тосон рашаан сувилал” ХХК-ний “Рашаан сувиллын цогцолбор” төслөөс байгаль орчинд нөлөөлөх байдлаараа Дунд нөлөөлөлтэй бөгөөд нөлөөллийн эрчим бага байна. Тухайлбал ус ашиглалт, түүний чанар, газрын элэгдэл, эвдрэл, ургамлан нөмрөг, аюул ослын магадлал, газрын төрх, хотгор гүдгэрийн өөрчлөлт, зэрэгт болзошгүй сөрөг нөлөөлөл нь Дунд зэрэг байх ба агаарын бохирдол, түүх соёлын өв, соёлыг түгээх, орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, орон нутгийн хөгжил зэрэгт бага болон дунд эрчмийн эерэг нөлөөлөлтэй байна. Мөн төслийн онцлох үйл ажиллагаа нь хүн амын эрүүл мэндэд байгалийн эрсдсээр эмчилгээ үзүүлэх онцлох эерэг нөлөөлөлтөй төсөл билээ.

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг илрүүлэх, хянахад оршино.

БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, ногоон байгууламжын ажил хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах зардлыг тусгасан болно.

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчин аялал жуулчлалын газрын асуудал хариуцсан газар хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаа эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн бичиг баримт болно.

2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” болон бусад холбогдох хууль, журам дүрэм, БОУАӨЯ-ны Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон тус журмын 2-р хавсралтын дагуу боловсруулсан болно.

Тус рашаан сувиллын цогцолборын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журмын тавигдсан шаардлагын дагуу тодорхойлж тусгав.

3.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Төслийн хүрээнд ашиглах авто тээврийг үзлэг оношилгоонд оруулж шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээ хийх	Автомашин	удаа	100,000	1	100.0	II улирал	Агаарын тухай хууль, MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Хөрс, газрын гадарга	Төслийн талбайн явган хүний зам талбайг хүртээмжтэй хэмжээнд тохижуулах	Хатуу хучилттай зам талбай	-	3000.0	-	3000.0	III улирал	Автомашин зогсоол, ангилал ерөнхий шаардлага MNS 5342:2025
3		Ашиглах газраа зориулалтын дагуу ашиглаж зөвхөн гэрээнд заагдсан үйл ажиллагаа явуулах	-	-	-	-	-	I-IV улирал	Хөрс, цөлжилтөөс хамгаалах тухай хууль
4	Усан орчин	Усыг хэмнэлттэй ашиглах тухай анхааруулах хуудас, санамжийг байршуулах	Объект бүрт	ш	20.0	10	200.0	II улирал	Усны тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай Усны чанар, хаягдал бохир ус MNS4943;2014

5		Тосон бүрд нуурыг хамгаалах, зөв зохистой ашиглах талаарх сургалт	Амрагч нарт	Удаа	65.0	10	650.0	II улирал	Усны нөөцийн бохирдлоос хамгаалах дүрэм. Байгаль орчин ба эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 143/A/352 хавсралт 1:1997 Бохир ус цэвэрлэх байгууламжийн
6		Хэрлэн голын сав газартай ус ашиглах гэрээ байгуулж дүгнүүлж ажиллах, төлбөр төлөх	Төслийн талбайд	удаа	Гэрээнд заасны дагуу төлбөр төлөх			I-IV улирал	байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS4288:1995
Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний нийт зардал –3,850,000 төгрөг									

3.2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэмж и х нэгж	Тоо хэмж ээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төслийн талбайн орчим нөлөөлөлд өртсөн талбайг нөхөн сэргээх	Олон наст ургамлын үр тариалж ургамалжуулах	Талхлагдс ан газруудад	2000м ²	10 кг	35.0	350.0	II улирал	Ургамлын тухай хууль MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамжуулах техникийн шаардлага
	Суулгац тарих /улиас, агч, голт бор, хайлаас гэх мэт	Өөрийн эзэмшлийн газарт	ш	200	5.0	1000.0	II, III улирал	Ургамал хамгааллын тухай хууль
Тэрбум мод төслийн хүрээнд орон нутагт ногоон байгууламж бий болгох	Хайлаас (Суулгац)	Орон нутгаас зааж өгсөн газарт	ш	200	3.0	600.0	II, III улирал	МУ Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөн
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн нийт зардал – 1,950,000 төгрөг								

3.3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.

3.4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгж зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хаягдал	Нийтийн эзэмшлийн талбай, үйлчилгээний орчинд ангилан ялгах боломж бүхий хогийн сав байрлуулах	Эдэлбэр газар	ш	60.0	3	180.0	I-IV улирал	Хог хаягдлын тухай хууль MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 4943:2015 ХБО. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
2		Хог хаягдлын гэрээг орон нутагтай байгуулж, график хугацааны дагуу зайлуулж байх	Үйл ажиллагааны хүрээнд	Удаа	Гэрээнд заасан дүнгээр ачуулах			I-IV улирал	
3		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах сургалт		Удаа	-	1	-	II, III улирал	
4		Төсөл хэрэгжих талбайгаас 50 м зай дах хог хаягдал, мөс цасыг цэвэрлэх	Төсөл хэрэгжих талбай	-	-	-	-	I-IV улирал	
5		Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах ач холбогдлын сургалт зохион байгуулах	Нийт ажилчдад	-	500.0	1	500.0	II улирал	



“Аварга тосон рашаан сувилал” ХХК - 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

6		Хог хаягдлын цэгийг ариутгах	Хогийн цэг	Удаа	400.0	1	400.0	I-IV улирал	
7		Нуурыг хамгаалах зорилгоор зуны улиралд 14 хоногт 1 удаа нуур орчмын хог хаягдлыг цэвэрлэх	Тосон болон Бүрд нуур	Сард 2 удаа	Дотоод зардлаар			II, III улирал	
8		Аюултай хог хаягдлыг тогтсон хугацаанд сумын эмнэлэгт нийлүүлэх	Сумын эмнэлэгтэй	тухай бүр	Гэрээний дүнгээр			II, III улирал	
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал – 1,080,000 төгрөг									

3.5. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Агаар дахь тоос тоосонцор, агаар бохирдуулагч бодис (SO ₂ , NO ₂ , PM _{2.5} , PM ₁₀)	Төслийн талбайд 2 цэгээс /авто зогсоол, амрагчдын байр/	II улирал	1	120.0	120.0	MNS 4585-2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384-1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,
2	Эмчилгээнд ашиглагдаж буй шавраас дээж авах	Эмчилгээнд ашиглаж буй байгалийн шавраас	II улирал	1	200	200	MNS 5848:2008 эмчилгээний шаврын ангилал. Техникийн шаардлага
3	Эмчилгээнд ашиглаад байгаль нийлүүлж буй нөхөн төлжиж буй шавраас дээж авах	Нөхөн төлжиж буй шавар	II улирал	1	200	200	
4	Ундны усны ерөнхий химийн шинжилгээ	Худаг-1 Гал тогоо-1	II улирал	2	90.0	180.0	MNS 0900-2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
5	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Ундны ус	II улирал	1	180.0	180.0	



“Аварга тосон рашаан сувилал” ХХК - 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

6	Хөрсөнд агрохимийн шинжилгээ хийх	Амрагчдын байр орчмоос	II улирал	1	70.0	70.0	MNS 5850:2019 хөрсний чанар, хөрс бохирдуулагч элементүүдийн дээд хэмжээ
7	Орчны хөрсөнд хүнд металл, эрүүл ахуй	Бохирын цооног, хогийн цэг орчмоос	II улирал	1	100	200	
8	Аварга тосон нуурын уснаас дээжлэлт хийх	Бактериологийн бүрэн шинжилгээ	II улирал	1	60.0	60.0	MNS 4047:1988. Усан мандал. Гадаргын усны чанарыг хянан журам
9	Бохир усанд шинжилгээ хийх	Бохирын цооног	II улирал	1	65.0	65.0	MNSISO5667-10;2001 Байгаль орчин. Усны чанар,Дээжлэлт10-р хэсэг: Хаягдал уснаас дээжлэлт хийх
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 1,275,000 төгрөг							

**3.6. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА- ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он					
			I улирал	II улирал	III улирал	IV улирал		
1	БОМТ-ийн төлөвлөгөөг батлагдсан журмын дагуу боловсруулан эрх бүхий байгууллагаар батлуулах тайлагнах	-					Захирал	БОМТ-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
2	Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөх, татан буугдах, барилга байгууламжийг бусдад шилжүүлэх, хөлслүүлэх, түрээслүүлэх зэрэг тохиолдолд тухайн хамгаалалтын захиргаанд мэдэгдэж гэрээнд нэмэлт, өөрчлөлт хийлгэж байх						Захирал	
3	Орон нутгийн засаг захиргаа, багийн иргэдийн саналыг сонсож, зохих арга хэмжээ авах, харилцан мэдээлэл солилцож байх						Менежер	БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам
4	Газар ус ашигласны болон бусад ажил, үйлчилгээ явуулж орлого олсны төлбөр, хураамжийг зохих журмын дауу цаг хугацаанд нь төлөх							Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон бусад
5	Байгаль орчны аудит хийлгэх	5,0 сая					Менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10.1 дүгээр зүйл



“Аварга тосон рашаан сувилал” ХХК - 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

6	Эрх бүхий төрийн байгууллагаас Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, ус ашиглах гэрээ байгуулан ажиллах	-					Менежер	Усны тухай хууль
Нийт- 5,000,000 төгрөг								

**4.8 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН
ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

БОМТ, БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газар	БОМТ хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлэх, тайлагнах	Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	10 сард	Дотоод зардлаар	Байгаль орчны ажилтан	Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум
БОУАӨЯ	2026 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг eic.mn сайтаар илгээж нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.	2026 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайлан	11 сарын 01 дотор	Дотоод зардлаар	Байгаль орчны ажилтан	-

ДҮГНЭЛТ

“Аварга тосон рашаан сувилал” ХХК нь Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Аварга багийн нутаг дэвсгэрт “Рашаан, сувилалын цогцолбор” төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны төлөв байдлын тайлан, мэргэжлийн байгууллага болох “Богдын өндөр сүрвэй” ХХК боловсруулж, БОУАӨЯ-ны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 2023 оны 06-р сард батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг тус тус үндэслэн боловсруулсан байна.

Байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийн бууруулах, арилгах заавар зөвлөмж, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, давтамж, хөрөнгө зардлыг тусгасан болно.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр :

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээнд 6 ажил- 3,850,000,

Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээнд 2 зорилтын хүрээнд 1,950,000,

Хог хаягдлын менежмент төлөвлөгөөнд сөрөг нөлөөлөл бууруулах 12 ажил -1,080,000,

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 9 чиглэлээр- 1,275,000 ,

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд 5,000,000 төгрөг байхаар тусгасан.

“Аварга тосон рашаан сувилал” ХХК-ийн 2026 оны БОМТ-ний үйл ажиллагаанд нийт 13,155,000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг зарцуулахаар төсөвлөсөн болно.